



НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ  
АЖИЛЛАГААНЫ ГАЗАРТ

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
**ЗАМЫН ХӨГЖЛИЙН ГАЗАР**

Нийслэлийн Засаг захиргааны II байр,  
Ц.Жигжиджавын гудамж, 1 дүгээр хороо,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160-0088  
Утас: (976-11) 32 53 85, Факс: (976-11) 32 44 98  
Цахим шуудан: info@road.ub.gov.mn  
Цахим хуудас: www.road.ub.gov.mn

2024.08.01 № 03/1655

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Албан хүсэлт хүргүүлэх тухай

Нийслэлийн Засаг даргын 2024 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн А/842 дугаар захирамжаар “Нийслэлийн үнэт цаасны хөрөнгөөр 2024 оны төсвийн жилд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалт”-ын “1”-д заасан “Авто зам, замын байгууламжийн засвар, шинэчлэлт, зураг төсвийн ажил (Улаанбаатар хот)”-ын хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалт батлагдсан.

Тус захирамжийн хавсралтын жагсаалтын 1, 14, 16, 17 дахь заалтын ажлуудын зураг төсөл боловсруулах эрхийг Нийслэлийн Засаг даргын 2024 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн А/685 дугаар захирамжаар Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ-т шилжүүлсэн байдаг.

Гүйцэтгэгч байгууллагаас ирүүлсэн зураг, төсөвтэй танилцаж, зураг, төсвийг шинэчлэн ирүүлэх тухай 2024 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 03/1625, 2024 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 03/1632 дугаартай албан бичиг тус тус хүргүүлсэн боловч одоог хүртэл шинэчилж ирүүлээгүй болно.

Иймд дээрх ажлуудын зарласан тендерийн нээх хугацааг тодорхойгүй хугацаагаар хойшлуулж өгнө үү.

Хавсралт 5 хуудастай.